Оюутны дасан зохицох чадварт нөлөөлөх зарим хүчин зүйлийн холбоо хамаарал

Б.Амарбаясгалан[1], У.Цэрэндолгор[2], М.Туул[3]

[1,2,3]Этүгэн их сургууль
Цахим шуудан: Amarbayasgalan87654@gmail.com, Утас: 95549553

Түлхүүр үг:

Мотиваци
Сэтгэц
Гэр бүл
Нас

Товч утга:

Үндэслэл: Бие махбод гадаад орчинтойгоо тасралтгүй тэнцвэртэй байх үйл явц нь дасан зохицол мөн. Орчин бие махбод хоёр байнга зөрчилтэй байдаг болохоор дасан зохицол нь энэ зөрчлийг байнга шийдвэрлэж байдаг үйл явц юм. Иймээс оюутны суралцахад сэтгэл зүйн байдал өөрчлөгдөж түүнд нөлөөлөх нийгэм, сэтгэлзүйн эрсдэлт хүчин зүйл, сэтгэцийн дасан зохицолыг судалсан судалгааны материал ховор байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Оюутны дасан зохицох чадварын түвшинг тодорхойлж зарим хүчин зүйлийн холбоо хамаарал, нөлөөлөх хүчин зүйлийг судлах. **Арга, аргачлал:** Этүгэн их сургуулийн Эрүүл мэндийн сургуулийн нэгээс тав дугаар дамжаанд суралцаж байсан оюутнуудаас 2020-2022 ондсанамсаргүй түүврийн аргаар 1356 оюутныг сонгон авч судалгааг хийв. **Үр дүн:** Судалгаанд оролцогч оюутнуудын дасан зохицох чадварын түвшингээр авч үзэхэд дасан зохицох чадвар дунджаас доогуур 79.1% (1073), дасан зохицох чадвар дундажтүвшинд 19.1% (259), дасан зохицох чадвар дунджаас дээгүүр 1.8% (24)-ийг эзэлж байв. Судалгаанд оролцогч оюутнуудын амжилтад хүрэх сэдлийг түвшингээр авч үзэхэд амжилтад хүрэх сэдэл бага 69.5% (964), дунджаас доогуур 23.8% (331), дундаж 5.5% (77), дунджаас дээгүүр 1.2% (16)-ийг эзэлж байв. Судалгаагаар амжилтад хүрэх сэдлийн түвшин болон суралцаж байгаа дамжааны хооронд урвуу сул ($r=-0.076^{**}$), амжилтад хүрэх сэдлийн түвшин, оюутны насны хооронд урвуу сул ($r=-0.12^{**}$) хамааралтай байгаа нь тодорхойлогдлоо. Дасан зохицох чадварын түвшин болон амжилтад хүрэх сэдлийн түвшин хооронд урвуу сул ($r=-0.209^{**}$), хамаарал ажиглагдсан нь статистик магадлалтай байна. **Дүгнэлт:** 1. Суралцаж байгаа дамжаа ахих, оюутны нас нэмэгдэхэд дасан зохицох чадварын түвшинг, гэр бүлийн харилцаа, хүмүүжил нь эерэг зөв байх нь амжилтад хүрэх сэдлийн түвшинг нэмэгдүүлж байна. 2. Оюутны амжилтад хүрэх сэдэлд гэр бүлийн харилцаа ($p<0.0001$), эрүүл мэндийн үнэлгээ ($p<0.05$), өвчин эмгэг ($p<0.0002$), сэтгэцийн эрүүл мэнд ($p<0.0001$) шугаман хамааралтай нөлөөлж байна.

Үндэслэл: "Эрүүл мэнд хүрээлэн буй орчны янз бүрийн хүчин зүйл, ачаалалд дасан зохицохдоо бие махбод, сэтгэц үйл ажиллагааны тогтвортой байдлыг (гомеостаз) хадгалах чадвар юм" гэж тэмдэглэжээ[1].

Биемахбод гадаад орчинтойгоо тасралтгүй тэнцвэртэй байх үйл явц нь дасан зохицол мөн. Өөрөө хэлбэл хувьслын үндсэн дээр юмуу, тогтворгүй байдлаар дамжин тогтвортой байдлыг хангах нь амьдралын болон дасан зохицлын диалетик томьёолол юм[2].

Орчин бие махбод хоёр байнга зөрчилтэй байдаг болохоор дасан зохицол нь энэ зөрчлийг байнга шийдвэрлэж байдаг үйл явц юм. Дасан зохицох үйл явцад дотоод орчны тэнцвэр (гомеостаз) ихээхэн ач холбогдолтой болохыг, түүхэн хувьсах өөрчлөлттийн явцад гоместазын механизм үйлчлэл илрэх бөгөөд улиран хувьсах нь үргэлжийн дасан зохицох үйл явц гэжээ. Аливаа тогтолцооны тогтвортой байдлыг хангаж байхын тулд зарим нэг хязгаар заавал байх болдог байна[3].

Дасан зохицол нь амьд бие махбодод хормын хугацаанд ч тасрахгүй явагдаж байдгийг Г.Селье (1960) тодорхойлон бичжээ. Ийнхүү дасан зохицохын хэмнэл,

хэлбэлзэл бүхий биологийн зүй тогтолтой холбож тайлбарлах нь түүний мөн чанарыг нээн илрүүлэх боломж олгож орчин цагийн биологи, анагаах ухааны зангилаа зарим асуудлыг тайлбарлах дөт замыг нээж байна[4].

Өмнөх үеүд хэрхэн төлөвшиж өнгөрсөнтэй холбоотой оюутан залуус бусадтай сэтгэл санаагаа хуваалцаж ойр дотно харилцаа тогтоох ур чадварыг эзэмшдэг бол зарим нь хайхрамжгүй, бусадтай дотно харилцаа тогтоох чадваргүй өөрийгөө бусдаас тусгаарлаж хөндий харьцаа үүсгэдэг. Эрик Эриксоний дурдсанаар хүн амьдралынхаа туршид хөгжлийн найман үе шатыг туулж үе шат бүрд чадвараа мэдрэхийн тулд шийдвэрлэх ёстой бэрхшээлүүдтэй тулгардаг бөгөөд энэ нь зөв дасан зохицсон насанд хүрсэн хүн болгон хөгжүүлэх боломжийг олгодог гэсэн байна[5].

Дасан зохицох чадварын түвшин биеийн шинж чанарын хөгжил хүний насны онцлогоос хамааран биеийн ачаалалд үзүүлэх хурд, хүч, уян хатан байдал, тэдний наснаас хамааран өөр өөр байдгыг эрдэмтэн судлаач Р.А.Абзаловын (2017) бүтээлд дурдсан[6].

Дасан зохицох, соёл, харилцааны ялгаа улам бүр төвөгтэй болж байгаа энэ үед олон улсын оюутнуудыг элсүүлдэг дээд боловсролын байгууллагууд энэ бэрхшээлийг ойлгох нь чухал ач холбогдолтой байна гэжээ[6]. Иймээс их дээд сургуулийн оюутны суралцахад сэтгэл зүйн байдал өөрчлөгдөж түүнд нөлөөлөх нийгэм, сэтгэлзүйн эрсдэлт хүчин зүйл, сэтгэцийн дасан зохицолыг судалсан судалгааны материал ховор байгаа нь энэхүү сэдвийг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Оюутны дасан зохицох чадварын түвшинг тодорхойлж зарим хүчин зүйлийн холбоо хамаарал, нөлөөлөх хүчин зүйлийг судлах.

Зорилт:

1. Оюутны сэтгэхүйн дасан зохицох чадварын болон амжилтад хүрэх сэдлийн түвшинд нөлөөлөх сэтгэл зүйн зарим хүчин зүйлийн холбоо хамаарлыг тогтоох.
2. Оюутны дасан зохицох чадварын болон амжилтад хүрэх сэдлийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээ хийх.

Арга, аргачлал: Судалгааг ажиглалтын судалгааны нэг агшны загвараар хийж гүйцэтгэв.

Судалгааны хүрээ: Этүгэн их сургуулийн Эрүүл мэндийн сургуулийн нэгээс тав дугаар дамжаанд суралцаж байсан оюутнуудаас 2020-2022 ондсанамсаргүй түүврийн аргаар 1356 оюутныг сонгон авч судалгааг хийв. Түүврийн хэмжээний алдаа 0.25%, итгэх түвшинг 95% байхаар тооцов[7,8].

Судалгааны хэрэглэгдэхүүн: Судалгааны хэрэглэгдэхүүнийг ОХУ-ын Эрхүү хотын АУДС-ийн Биеийн тамир, Эрүүл мэндийн төвөөс боловсруулсан оюутны эрүүл амьдралын хэв маяг, амжилтад хүрэх сэдлийн түвшин, бие хүний дасан зохицохыг олон түвшинд үнэлэх сорилоор албан ёсны зөвшөөрөл авч ашигласан.Судалгааны асуумжийг google forms дээр байршуулж оюутнуудаас асуумжийн дагуу хариултыг авав.

1. 13 асуумж бүхий судалгааны картаар асуумж авав.
2. Бие хүний дасан зохицох чадварыг олон түвшинд үнэлэх сорилоор дараахи түвшинд үнэлэв. Үүнд:

1. Дасан зохицох чадвар (багатай, боломжийн буюу дундаж, өндөр ба хэвийн)
2. Мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын түвшин (дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр)
3. Харилцааны чадварын түвшин (дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр)
4. Ёс суртахууны хэм хэмжээний түвшин (дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр)

3. Амжилтад хүрэх сэдлийн түвшин (бага, дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр, өндөр) тодорхойлж хэрэглэгдэхүүнийг цуглуулав

Судалгааны статистик боловсруулалтыг SPSS-23 программаар харьцангуй үзүүлэлтүүд, бүлгүүдийн ялгааг хи квадратаар, хамаарлыг Пирсоны коэффицентоор нөлөөлж буй хүчин зүйлийг шугаман регрессийн аргаар тооцоолж хийж гүйцэтгэв[7,8].

Үр дүн: Судалгаанд оролцогч оюутнуудын дасан зохицох чадварын түвшингээр авч үзэхэд дасан зохицох чадвар дунджаас доогуур 79.1% (1073), дасан зохицох чадвар дундаж түвшинд 19.1% (259), дасан зохицох чадвар дунджаас дээгүүр 1.8% (24)-ийг эзэлж байна. Судалгаанд дасан зохицох чадвар дундаж болон дунджаас доогуур түвшинтэй оюутнууд илүү хамрагдсан байна.

Оюутны ёс суртахууны хэм хэмжээг дунджаас доогуур 10.9% (151), дундаж түвшинд 84.3% (1155), дунджаас дээгүүр түвшинд 5.8% (80)-ийг эзэлж байна. Мөн оюутны мэдрэл сэтгэцийн тогтвортой байдал дунджаас доогуур түвшинд 78.4% (1063), дундаж түвшинд 21.6% (293)-ийг эзэлж судалгаанд мэдрэл сэтгэцийн тогтвортой байдал дунджаас дээгүүр түвшинд тодорхойлогсон тохиолдол байгаагүй нь анхаарал татаж байна.

Харилцааны чадварыг үнэлэхэд дунджаас доогуур түвшинд 36.2% (491), дундаж түвшинд 59.6% (808) нь дунджаас дээгүүр түвшинд 4.2% (57)-ийг эзэлж байна.

Судалгаанд оролцогч оюутнуудын амжилтад хүрэх сэдлийг түвшингээр авч үзэхэд амжилтад хүрэх сэдэл бага 69.5% (964), дунджаас доогуур 23.8% (331), дундаж 5.5% (77), дунджаас дээгүүр 1.2% (16)-ийг эзэлж байна.

Судалгаагаар амжилтад хүрэх сэдлийн түвшин болон суралцаж байгаа дамжааны хооронд урвуу сул ($r=-0.076^{**}$), амжилтад хүрэх сэдлийн түвшин, оюутны насны хооронд урвуу сул ($r=-0.12^{**}$) хамааралтай байна. Өөрөөр хэлбэл суралцаж байгаа дамжаа ахих, нас нэмэгдэхэд амжилтад хүрэх сэдлийн түвшин буурч байна.

Дасан зохицох чадварын түвшин болон суралцаж байгаа дамжааны хооронд шууд сул ($r=0.129^{**}$), дасан зохицох чадвар болон оюутны насны хооронд шууд сул ($r=0.145^{**}$) хамааралтай байна. Өөрөөр хэлбэл дамжаа ахих, оюутны нас нэмэгдэхэд

дасан зохицох чадварын түвшин нэмэгдэж байна.

Дасан зохицох чадварын түвшин болон гэр бүлийн харилцааны хооронд (r=-0.123**), хайр дурлал үерхэл нөхөрлөлийн хооронд (r=-0.075**) хүмүүжил (r=-0.063**) эрүүл мэнддээ өгсөн үнэлгээний хооронд (r=-0.179**) тус тус урвуу сул, дасан зохицох чадвар болон бие махбодын өвчний хооронд (r=0.122**) сэтгэцийн өвчний хооронд (r=-0.179**) тус тус шууд сул хамааралтай нь статистик магадлалтай байна.

Оюутны амжилтад хүрэх сэдлийн түвшин, мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын, харилцааны чадварын, ёс суртахууны хэм хэмжээний, дасан зохицох чадварын түвшин хоорондын хамаарлыг тодорхойлов. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Оюутны амжилтад хүрэх сэдлийн түвшин, дасан зохицох чадвар хоорондын хамаарал (r)

Түвшин	Дасан зохицох чадварын	Мэдрэл сэтгэцийн тогтвортой байдал	Харилцааны чадвар	Ёс суртахууны хэм хэмжээ чадварын
Амжилтанд хүрэх сэдлийн	-0.209**	-0.254**	-0.17**	-0.63*
Дасан зохицох чадварын		0.89**	0.692**	0.55**
Мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын			0.637**	0.515**
Харилцааны чадварын				0.382**

Тайлбар: **P<0.05**P<0.001*

Дасан зохицох чадварын түвшин болон амжилтад хүрэх сэдлийн түвшин хооронд урвуу сул (r=-0.209**), мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлийн хооронд (r=0.89**), харилцааны чадварын түвшний хооронд (r=0.692**) шууд хүчтэй, ёс суртахууны хэм хэмжээний чадварын хооронд (r=0.55***) шууд дунд зэргийн хамаарал ажиглагдсан нь статистик магадлалтай байв.

Өөрөөр хэлбэл мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын түвшин болон дасан зохицох чадварын хооронд (r=0.89**), харилцааны чадварын хооронд (r=0.637**) тус тус хүчтэй, ёс суртахууны хэм хэмжээний хооронд (r=0.515***) шууд дунд зэргийн, амжилтад хүрэх сэдлийн түвшин хооронд (r=-0.254**) урвуу сул хамааралтай байв.

Оюутны харилцааны чадварын түвшин ёс суртахууны хэм хэмжээний чадварын хооронд (r=0.382**) шууд дунд зэргийн хамааралтай нь статистик магадлалтай байв.

Судалгаагаар нэг хүчин зүйлийн шинжилгээгээр оюутны нас (B=-0.103; 95%CI (-0.17-0.026) p=0.008) 1жилээр нэмэгдэхэд дасан зохицох чадварын түвшин -0.103 дахин буурч байгаа бөгөөд P<0.008 байгаа нь дасан зохицох чадварын түвшин настайурвуу шугаман хамааралтайг харуулж байна.

Оюутны ДЗЧ-т нөлөөлж буй хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээний үр дүн: Оюутны дасан зохицох чадварт нөлөөлж буй хүчин зүйлийн нэг ба олон хүчин зүйлийн шугаман регресийн шинжилгээний үр дүнг хүснэгт 2-оор үзүүлэв.

Хүснэгт 2. Дасан зохицох чадварт нөлөөлж буй нэг ба олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Нэг хүчин зүйл			Олон хүчин зүйл		
	B	95%CI	P утга	B	95%CI	P утга
Нас	-0.103	-0.17-0.026	0.008	0.246	0.158-0.333	0.0001
Үндсэн харьяалал	0.112	0.012-0.213	0.029			

Судалгаанаас үзэхэд (хүснэгт 2) нэг хүчин зүйлийн шинжилгээгээр оюутны нас (B=-0.103; 95%CI (-0.17-0.026) p=0.008) 1жилээр нэмэгдэхэд дасан зохицох чадварын түвшин -0.103 дахин буурч байгаа бөгөөд P<0.008 байгаа нь дасан зохицох чадварын түвшин настайурвуу шугаман хамааралтайг харуулж байна.

Оюутны амжилтад хүрэх сэдлийн түвшинд нөлөөлж буй нэг ба олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээний үр дүнг хүснэгт 3-аар үзүүлэв.

Хүснэгт 3. Оюутны амжилтад хүрэх сэдлийн түвшинд нөлөөлж буй нэг ба олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Нэг хүчин зүйл			Олон хүчин зүйл		
	B	95%CI	P утга	B	95%CI	P утга
Гэр бүлийн харилцаа	0.211	0.162-0.45	0.0001	-0.12	-0.2-0.04	0.003
Эрүүл мэнддээ өгсөн үнэлгээ	0.125	-0.001-0.251	0.05	-0.18	-0.254-0.114	0.0001
Бие махбодын өвчин	0.272	0.096-0.44	0.0002	0.177	0.011-0.343	0.037
Сэтгэцийн өвчин	0.867	0.449-1.28	0.0001	0.534	0.195-0.874	0.002

Судалгаанаас үзэхэд (хүснэгт 32) нэг хүчин зүйлийн шугаман регресийн шинжилгээгээр оюутны гэр бүлийн харилцаа(B=0.211; 95%CI; (0.162-0.45); p<0.0001) эвтэй найртай байхад амжилтад хүрэх сэдлийн түвшин 0.211 дахин нэмэгдэж байгаа бөгөөд P<0.0001байгаа нь амжилтад хүрэх сэдлийн түвшин гэр бүлийн харилцаатай шугаман хамааралтайг харуулж байна.

Эрүүл мэнддээ өгсөн үнэлгээгээр оюутны эрүүл мэнд онц сайн, сайн байхад(B=0.125 95%CI (-0.001-0.251) p<0.05) амжилтад хүрэх сэдлийн түвшин 0.125 дахин нэмэгдэж, P<0.05байгаа нь амжилтад хүрэх сэдлийн түвшин эрүүл мэндтэй шугаман хамааралтайг харуулж байна.

Бие махбодын өвчингүй байхад (B=0.272 95%CI (-0.096-0.44) p=0.0002) амжилтад хүрэх сэдлийн түвшин 0.272 дахиннэмэгдэж байгаа бөгөөд P<0.0002 бие махбодын өвчингүй байх, амжилтад хүрэх сэдлийн хооронд шугаман хамааралтайг харуулж байна.

Оюутан сэтгэцийн хувьд эрүүл байхад (B=0.867 95%CI (0.449-1.28) p<0.0001) амжилтад хүрэх сэдлийн түвшин 0.867 дахин нэмэгдэж байгаа бөгөөд P<0.0001байгаа нь сэтгэцийн өвчин, амжилтад хүрэх сэдлийн түвшин хооронд шугаман хамааралтайг харуулж байна.

Оюутны мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын түвшин (B=-0.452; 95%CI (-0.603-0.302); p<0.0001) дунджаас доогуур байхад дасан зохицох чадвар -0.452 дахин буурч байгаа бөгөөд P<0.0001байгаа нь дасан зохицох чадварын түвшин нь мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын түвшинтэй, оюутны харилцааны чадварын түвшин (B=0.164 95%CI (0.141-0.187) p<0.0001) дундаж түвшинд байхад дасан зохицох чадварын түвшин 0.164 дахин нэмэгдэж (p<0.0001) дасан зохицох чадварын түвшин, харилцааны чадварын түвшин хооронд шугаман, ёс суртахууны хэм хэмжээний чадварын түвшин (B=0.105 95%CI (0.08-0.13) p<0.0001) дундаж түвшинд байхад дасан зохицох чадварын түвшин 0.105 дахин нэмэгдэж байгаа бөгөөд P<0.0001байгаа нь дасан зохицох чадварын түвшин нь ёс суртахууны хэм хэмжээний чадварын түвшинтэй шугаман хамааралтайг тус тус харуулж байна.

Олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээгээр оюутны мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын түвшин (B=0.53; 95%CI 0.51-0.556; p<0.0001) дунджаас доогуур байхад дасан зохицох чадвар 0.53 дахин буурч байгаа бөгөөд P<0.0001байгаа нь дасан зохицох чадварын түвшин нь мэдрэл сэтгэцийн тогтвортой байдлын түвшинтэй, оюутны харилцааны чадварын түвшин (B=0.1695%CI (0.141-0.187) p<0.0001) дундаж түвшинд байхад дасан зохицох чадварын түвшин 0.16 дахин нэмэгдэж байна.p<0.0001 байгаа нь харилцааны чадварын түвшин дасан зохицох чадварын түвшинтэй, ёс суртахууны хэм хэмжээний түвшин (B=0.1 95%CI 0.08-0.13; p<0.0001) дундаж түвшинд байхад дасан зохицох чадварын түвшин 0.1 дахин нэмэгдэжP<0.0001байгаа нь дасан зохицох чадварын түвшин нь ёс суртахууны хэм хэмжээнийтүвшинтэй шугаман хамааралтайг тус тус харуулж байна.

Хэлцэмж: Судлаач Кожевнизова.Н.Г нар (2011)-ын бүтээлд оюутны чөлөөт цаг бага байгаагийн шалтгаан нь чөлөөт цагаа анзаарахгүй байх, оновчтой ашиглахгүй, хамгийн гол нь оюутны чөлөөт цагийн үнэ цэнэ бага байна гэж дүгнэжээ. Оюутны амжилтад хүрэх сэдлийн түвшин өндөр байх нь үнэ цэнэтэй төдийгүй бие хүний хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ. Одоогийн байдлаар 1-р курсын оюутны дунд эрүүл амьдралын хэв маягийг хөгжүүлэх сэдэл, хандлагыг хөгжүүлэхэд багш нар ихээхэн анхаарал хандуулж байхыг тэмдэглэжээ[9].

Судлаач Колесникова А. Ю (2015)-н бүтээлд оюутны эрүүл мэндийн байдал нь тэдний сурч боловсрох, амьдрах чөлөөт цагаа өнгөрүүлэх, ирээдүйн талаарх бодол санаа, бие махбодын болон оюун санааны сонирхол, сэтгэл хангалуун байх зэрэг үзүүлэлтээр илэрдэг болохыг тэмдэглэжээ[10].

Тэрээр ихэнх оюутнууд эрүүл мэндээ хамгаалах эрүүл амьдралын хэв маягийн талаар онолын ойлголттой байдаг. Гэвч оюутнууд тайван амьдралын хэв маягийг баримталж бие бялдрын хөгжлийнхөө хэрэгцээг бий болгоогүй байна. Иймээс оюутны эрүүл амьдралын хэв маягийг сэдээх асуудал нэлээд хурцаар тавигдаж байна гэж тэмдэглэсэнтэй бид санал нэг байна.

БНХАУ-ын оюутнуудын дасан зохицох чадвар өндөр байгааг нотолсон шалтгаан нь оросын боловсролыг сурах хүсэл тэмүүлэл, урам зоригоор, сэдэл тэмүүлэлтэй нь тодорхойлогддог. Мөн Орос улсын оюутнуудын 40% хятад оюутнуудын 11 хүн тутмын 3 нь дунд зэргийн дасан зохицох чадвартай. Орос улсын оюутнуудын 20 орчим хувь нь, хятад оюутны 11 хүн тутмын 7 (63.6%) нь дасан зохицох чадварын доод түвшинд байна гэж тэмдэглэсэн бол бидний судалгаанд оюутнуудын дасан зохицох чадварын түвшин дунджаас доогуур 79.1% (1073); дасан зохицох чадвар дундаж түвшинд 19.1% (259); дасан зохицох чадвар дунджаас дээгүүр 1.8% (24)-ийг эзэлсэн байна[10].

Хятад улсын оюутнуудын дасан зохицох чадварт сөргөөр нөлөөлж буй дараах хүчин зүйлүүд байна.Орос хэлниймэдлэг сул, орос хэл дээр суралцах нь боловсролын байгууллагын шаардлага, харилцааны чадвар, хувь хүний болон хувийн шинж чанарууд (Танин мэдэхүйн чадварыг хангалтгүй хөгжүүлж) юм. Судалгааны үр дүнд нэгдүгээр курсын оюутны дасан зохицох үйл явцад нөлөөлж буй хүчин зүйлүүд Үүнд:

1. Субъектив шинж чанарын хүчин зүйлүүд (нас, суурь боловсролын түвшин)
2. Зорилго хүчин зүйл (бүлгийн хэмжээ, бүлгийн стандарт систем, дээд боловсролын байгууллагын шаардлага, дадлага хийх газар байгаа эсэх (сургалт), багш нарын мэргэжлийн ур чадвар, ёс зүйн хэм хэмжээ, нийгмийн байдал, гэр бүлийн харилцааны байдал зэрэг хүчин зүйлүүд тодорхойлогджээ[11].

Бидний судалгааны дүнтэй энэхүү дүнг харьцуулахад19 хүртэл насны 513 оюутны 40% (419) дасан зохицох чадварын түвшин дунджаас доогуур, 30.1% (78) нь дундаж түвшинд, 25% (6) нь дунджаас дээгүүр түвшинд, 20-24 насны 732 оюутны 53.1% (570)

дунджаас доогуур, 58.3% (151) нь дундаж түвшинд, 45.8% (11) дунджаас дээгүүр түвшинд тодорхойлогдсон нь дийлэнх хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл оюутны дасан зохицох чадварын түвшин, насны бүлгүүдийн хооронд ялгаатай (χ^2=29.016, P=0.0001)байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Дүгнэлт:

1. Дасан зохицох чадварын түвшин болон суралцаж байгаа дамжааны хооронд шууд сул (r=0.129**), дасан зохицох чадвар болон оюутны насны хооронд шууд сул (r=0.145**) хамааралтай байна. Өөрөөр хэлбэл дамжаа ахих,оюутны нас нэмэгдэхэд дасан зохицох чадварын түвшин, гэр бүлийн харилцаа, хүмүүжил нь эерэг зөв байх нь амжилтад хүрэх сэдлийн түвшинг нэмэгдүүлж байна.
2. Оюутны дасан зохицох чадварт нэг хүчин зүйлийн шинжилгээгээр нас, (p<0.008) олон хүчин зүйлийн шинжилгээгээр мэдрэл сэтгэцийн тогтортой байдал(p<0.0001), харилцааны чадварын түвшин(p<0.0001), ёс суртахууны хэм хэмжээний түвшин (p<0.0001) шугаман хамааралтай нөлөөлж байна.Оюутны амжилтад хүрэх сэдэлд гэр бүлийн харилцаа (p<0.0001), эрүүл мэндийн үнэлгээ (p<0.05), өвчин эмгэг (p<0.0002), сэтгэцийн эрүүл мэнд (p<0.0001) шугаман хамааралтай нөлөөлж байна.

Ном зүй:

1. *Айзман, Р.И. Методические аспекты определения индивидуальной нормы в онтогенезе человека / Р.И. Айзман //Актуальные вопросы биомедицинской и клинической антропологии: тез. док. Томск; Красноярск, 1996 -С. 8.*
2. *Агаджанян.Н.А,Баевский Р.М, Берсенева А.П. Учение о здоровье и проблемы адаптации / - М.; Ставрополь, 2000. - 203 с*
3. *https://dnkom.ru/o-kompanii/stati/diagnostika-v-detalyakh/stadii-stressa/ 2022.10.13*
4. *https://psychology-mn.blogspot.com/2011/03/blog-post_24.html2022.12.23*
5. *https://naukarus.com/fakultetu-fizicheskoy-kultury-gou-vpo-tatarskiy-gosudarstvennyy-gumanitarno-pedagogicheskiy-universitet-60-let2023.03.04*
6. *Абзалов Р.Р. Адаптация насосной функции сердца к мышечной деятельности /Р.Р.Абзалов, Н.И.Абзалов, Р.А.Абзалов, А.А.Гуляков // Человек. Спорт. Медицина. 2017. Т. 17. № S. С. 7-11.*
7. *Даваалхам Д. Биостатистик УБ 2011 х260*
8. *Туул М., Лхагва Л., Амгаланбаатар Д. Монгол хүний хөгшрөлтийн биологи 7-р дэвтэр УБ: Соёмбо принтинг 2018. х39-44*
9. *Сарантуяа Р. Сэтгэцийн оношлогоо УБ 2021 Х34-41*
10. *Ефимова, И.В. Физическая культура и индивидуальное здоровье / И.В. Ефимова, Н.К. Ковалев, Р.Ф. Проходовская, Учеб.-метод. пособие. Иркутск: 2008. - 45 с.*
11. *Колесникова А. Ю., Пантелеева Е. Л., Яскина И. В., Добровольская А. К., Дубынина К. А. Анализ компонентов мотивационноценностного отношения к ЗОЖ у студентов третьей функциональной группы С 54*
12. *Tserendolgor U., Gantsetseg T-O., Munkhjargal B., Khaibar T., Lebedinskiy V. YU., Sukhinina K. V., Kolesnikova A. YU. Study of first year university student's adaptation and motivation Physical training and sports 163*
13. *Forbush E., Foucault-Welles B. (2016). Social media use and adaptation among Chinese students beginning to study in the United States. International Journal of Intercultural Relations, Volume 50, January 2016, P. 1–12.*
14. *Shevelyov, G.E., Kabanova, L.I. and Mikhalchenko, E.V. (2012). Information system for an assessment of adaptation of foreign students. Bulletin of science of Siberia, 1 (2): 134-138.*
15. *Vadutova, F.A., L.I. Kabanov, G.I. Shkatov (2010). Assessment and forecasting of adaptation of foreign students to training conditions in the Russian higher educational institutions. TSPU Bulletin, 12: 123-126.*

Correlation of some factors affecting students' adaptability

Amarbayasgalan B[1], Tserendolgor U[2], Tuul M[3]

[1,2,3]Etugen university
E-mail: Amarbayasgalan87654@gmail.com, Tel: +976-95549553

Background: Adaptation is the process by which the body continuously balances with its external environment. Since the environment and the body are always in conflict, adaptation is a process that constantly resolves this conflict. Therefore, the lack of research materials that study the social and psychological risk factors and mental adaptation that affect the student's psychological state, is the reason for choosing this research topic.
Aim: It is to determine the level of students' adaptability and study the relationship between some factors and influencing some factors.
Materials and Methods: 1356 students were randomly selected from first to fifth-year students who studied at the Medical School of Etugen University from 2020 to 2022 and conducted the study.
Results: Considering the level of adaptability of the students participating in the research, the adaptability is below the average at 79.1% (1073); 19.1%(259) at the average level of adaptability; adaptability is above average at 1.8% (24). When considering the level of motivation of students participating in the study, 69.5% (964) had low motivation, 23.8% (331) below average, 5.5% (77) average, and 1.2% (16) above average. According to the research, there is a weak inverse relationship between the level of motivation to achieve success and the course being studied (r=-0.076**), and a weak inverse relationship between the level of motivation to achieve success and the student's age (r=-0.12**). A weak inverse relationship (r=-0.209**) was observed between the level of adaptability and the level of motivation to achieve, which is statistically probable.
Conclusions:

1. The level of ability to adapt to the advancement of the course of study, the increase in the students' age, and the positive and correct family relations and upbringing increase the students' motivation level to achieve success.
2. Family relationship ($p<0.0001$), health evaluation ($p<0.05$), illness ($p<0.0002$), and mental health ($p<0.0001$) have a linear relationship with students' motivation to achieve success.

Keywords: Motivation, Mental, Family, Age